

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ШИВЭЭ-ОВОО” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

2020.03.13 № 06/857
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-овоо ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шивээ-овоо ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шивээ-овоо ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Шивээ-овоо ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ СТОУС, НББОУС, Монгол улсад мөрдөгдөж байгаа бусад хууль түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын өөрчлөлтүүдийг тусгаж шинэчлэх, авлагыг богино хугацаанд хураан барагдуулах, хугацаа хэтэрсэн авлага үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах, компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Шивээ-Овоо ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2020 оны 2 дугаар сарын 15-аас 2020 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор Ц.Алтанцэцэг, Л.Оюун-эрдэнэ, чанарын хяналтын менежер Б.Бямбасүрэн, аудиторын туслах Н.Гэрэлцэцэг, Б.Марал, Э.Цэнд-аюуш, Г.Цэдэн-иш нар хэрэгжүүлэв.

Шивээ-Овоо ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 3/238 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт, 3/237 тоот албан “Пантер мидланд аудит” ХХК-д тус тус ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шивээ Овоо ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгаль орчинд сөрөг нөлөө учруулдаггүй, дэлхийн түвшинд хүрсэн тэргүүний техник технологийг түшиглэж, хэрэглэгчдийн эрэлт шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ төрийн болон хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай шударга бизнес эрхэлнэ” гэж тодорхойлжээ

Шивээ-Овоо ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны чиглэл 101000: Чулуун нүүрс олборлолт
- *Туслах үйл ажиллагааны чиглэл:*
 - ✓ Үйл ажиллагааны чиглэл 521100: Өргөн хэрэглээний барааны дэлгүүр
 - ✓ Үйл ажиллагааны чиглэл 552000: Гуанз, цайны газрын үйлчилгээ
 - ✓ Үйл ажиллагааны чиглэл 154100: Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Шивээ-Овоо ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр тогтоол “2019 оны бизнес төлөвлөгөө”-г батлах тухай
- Шивээ-Овоо ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоол “Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг дүгнэх тухай”
- Шивээ-Овоо ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоол 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол Шивээ-Овоо ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг батлах тухай”
- Шивээ-Овоо ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоол “Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсөв батлах тухай”
- Шивээ-Овоо ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоол “Үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай”
- Шивээ-Овоо ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 09 дүгээр тогтоол “Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай”
- Шивээ-Овоо ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоол “Зээл авах зөвшөөрөл олгох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Шивээ-Овоо ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Silicon 3.0” программ хангамж ашигладаг байна.

Шивээ-Овоо ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шивээ-Овоо ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 26,690.2 сая төгрөгөөс тооцон 533.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,266.9 сая төгрөгөөр тооцсон нь тус компани төрийн өмчит хувьцаат компани учраас батлагдсан төсөв, төлөвлөөг хянахын тулд зардлын дансыг сонгох нь зохимжтой гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 196.5 сая төгрөгөөр буюу 0.16 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,357.3	1,210.8	(146.5)
Авлага	7,368.1	7,434.8	66.7
Бусад авлага	663.6	127.9	(535.8)
Найдваргүй авлагын нөөц	(3,191.0)	(3,191.0)	0.0
Урьдчилгаа	4,058.5	2,918.0	(1,140.5)
Бараа материал	14,639.9	14,871.2	231.3
Үндсэн хөрөнгө	66,807.5	68,768.5	1,961.0
Биет бус хөрөнгө	27.5	68.4	40.9
Хойшлогдсон татварын хөрөнгө	(2,674.1)	(2,674.1)	0.0
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	530.1	530.1	0.0

Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,066.8	786.2	(280.6)
Хөрс хуулалтын хөрөнгө	34,287.3	34,287.3	0.0
Нийт хөрөнгө	124,941.6	125,138.1	196.5
Өр төлбөр	120,124.8	127,713.4	7,588.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,207.7	1,207.7	0.0
- хувийн	134.2	134.2	0.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,475.0	(3,917.2)	(7,392.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	124,941.6	125,138.1	196.5

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 469.1 сая төгрөгөөр буурсан нь 2019 онд ТУЗ-ийн тогтоолоор авлага бууруулах ажлын хэсэг байгуулагдаж авлагыг барагдуулсан байна.

Авлага дансны үлдэгдэлд 2017-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 320.1 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Энэ нь шүүхээр шийдвэрлүүлсэн боловч эзэн холбогдогч нь олдохгүй, татсан буугдсан аж ахуйн нэгж байгууллагуудын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 231.2 сая төгрөгөөр өссөн. 2017-2019 онд хөдөлгөөн хийгдээгүй 7,271.0 сая төгрөгийн сэлбэг, бараа материал байгаа бөгөөд энэ нь нийт бараа материалын 48.8 %-ийг эзэлж байна. Ашиглагдахгүй байгаа сэлбэг, бараа материалыг худалдан борлуулахаар туршин үзсэн бөгөөд зохих үр дүнд хүрээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,960.9 сая төгрөгөөр өссөн ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг худалдаж авсантай холбоотой. Хөрөнгө оруулалтаар 10,467.9 сая төгрөгийн, хоорондын шилжилт хөдөлгөөнөөр 5,805.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Мөн 8,530.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 48.8 сая төгрөгөөр өссөн ба санхүүгийн програм хангамжийг сайжруулсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,588.6 сая төгрөгөөр өссөн. Богино хугацаат өр төлбөр 7,658.4 сая төгрөгөөр өссөн, урт хугацаат өр төлбөр 69.8 сая төгрөгөөр буурсан.

Урт хугацаат өр төлбөрт урт хугацаат зээл 2,596.8 сая төгрөг, засгийн газрын дэмжлэг 59,195.8 сая төгрөг, хойшлогдсон татварын өр 358.5 сая төгрөг, бусад урт хугацаат өр төлбөр 12,861.4 сая төгрөг, ажилчдын тэтгэврийн сан 1,218.5 сая төгрөгөөр бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд урт хугацаат өр төлбөр 76.231.3 сая төгрөг буюу 59.6 богино хугацаат өр төлбөр 51,482.0 сая төгрөг буюу 40.4 хувийг тус тус эзэлж байна.

2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шивээ-Овоо ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 2019 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Хувь	Зөрүү
А. Уулын ажлын үзүүлэлт						
1	Нүүрс олборлолт	с.тн	2.0	1.9	95.0	(0.1)
2	Нүүрс борлуулалт	с.тн	2.0	2.0	100.0	-
3	Тээвэртэй хөрс хуулалт	с.м ³	6.5	6.2	95.4	(0.3)
4	Тээвэргүй хөрс хуулалт	с.м ³	2.2	2.3	104.5	0.1
5	Дахин шидэлт	с.м ³	2.7	2.4	88.9	(0.3)
6	Нийт хөрс хуулалт	с.м³	8.7	8.5	97.7	(0.2)
7	Инженер ажил	с.м ³	0.5	0.8	161.7	0.3
8	Нийт уулын цул	с.м³	13.2	13.4	101.5	0.2

2019 онд 2.0 сая тонн нүүрс олборлон борлуулах, 8.7 сая м³ хөрс хуулах төлөвлөгөөтэй ажилласнаас нүүрс олборлолт 1.9 сая тонн, борлуулалтын хэмжээ 2.0 сая тонн болж төлөвлөгөө 100 хувийн, хөрс хуулалтын хэмжээ 8.5 сая м³ болж төлөвлөгөө 97.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Хөрс хуулалтын ажлыг дотор нь салгаж үзвэл тээвэртэй хөрс хуулалт 6.2 сая м³ буюу 95.4 хувь, тээвэргүй хөрс хуулалт 2.3 сая м³ буюу 104.5 хувийн биелэлттэй ажилласан байна.

2019 оны уулын ажлын төлөвлөгөөнд 2.0 сая тонн нүүрс олборлож борлуулахаар тооцсон байна. Энэ нь өмнөх жилээс 0.5 хувиар буурч, төлөвлөснөөс 0.5 хувиар илүү байна.

Хүснэгт 3. Нийт орлого, зардлын судалгаа:

Д.д	Үзүүлэл	Хэм нэгж	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Борлуулалтын орлого	сая төг	59,270.0	55,673.5	93.9	3,596.5
2	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	145.0	212.1	146.3	(67.1)
3	Нийт орлого	сая төг	59,415.0	55,885.6	94.1	3,529.4
4	Үйлдвэрлэлийн зардал	сая төг	54,425.8	60,909.8	111.9	(6,484.0)
5	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	1,627.4	2,438.2	149.8	(810.8)
6	Нийт зардал	сая төг	56,053.2	63,348.0	113.0	(7,294.8)
7	Татварын өмнөх ашиг	сая төг	3,361.8	(7,462.4)	(222.0)	10,824.2
8	ААНОАТ	сая төг	336.2	2.0	0.6	334.2
9	Татварын дараах ашиг	сая төг	3,025.6	(7,464.4)	(246.7)	10,490.0

Тайлант жилд нийт орлого 55,855.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс үндсэн үйл ажиллагаанаас 55,673.6 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 212.1 сая төгрөгийн орлого тус тус олсон байна.

2019 онд борлуулалтаас 59,270.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 55,673.5 сая төгрөгийн орлого олж 93.9 хувийн гүйцэтгэлтэй гарч орлогын төлөвлөгөөг 6.1 хувиар тасалжээ.

Нийт орлого өмнөх оноос 4,565.5 сая төгрөг буюу 8.9 хувиар өссөн, төлөвлөснөөс 3,529.2 сая төгрөг буюу 5.9 хувиар дутуу байна.

Орлого буурсан шалтгаан нь нэг тонн нүүрсний нэгжийн үнийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 3,000.0 төгрөгөөр нэмэгдүүлж 30,060.0 төгрөг болохоор төлөвлөсөн боловч Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 374 тоот тогтоолоор эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй нэг тн нүүрсний үнийг 2,000.0 төгрөгөөр нэмэгдүүлж 29,060.0 төгрөг болгож тус үнийг 2019 оны 08 дугаар сарын 01-ээс мөрдсөнтэй холбоотойгоор борлуулалтын орлого буурсан.

2019 онд үндсэн үйл ажиллагаанд 54,425.8 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 60,909.9 сая төгрөгийн зардал гарч 111.9 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Нийт зардал 63,348.0 сая төгрөгт хүрч өмнөх оноос 9,398.2 сая төгрөг буюу 17.4 хувиар өссөн, төлөвлөснөөс 13.0 хувиар буюу 7,293.7 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Зардал хэтэрсэн шалтгаан нь Хөрс хуулалтын хойшлох зардлыг төлөвлөгөөнд 3,388.5 сая төгрөгөөр тусгаж нийт үйлдвэрлэлийн зардлыг тэр хэмжээгээр бууруулсан бол гүйцэтгэлээр 2,600.0-3,400.0 сая төгрөгийг хойшлуулаагүйтэй холбоотой.

Түүнчлэн Цахилгаан эрчим хүчний зардал 13.9 хувь буюу 417.5 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоол болон 2019 оны 03 дугаар 25-ны өдрийн 111, 112, 113, 114 тоот тогтоолуудаар батлагдсан чадал тариф болон дэмжих тарифын өсөлттэй холбоотой байна.

Тайлант жилд 3,024.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, 7,464.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан шалтгаан нь:

1. Борлуулалтын орлого 3,569.3 сая төгрөгөөр тасарсан.
2. Үйл ажиллагааны бус зардал 809.7 сая төгрөгөөр хэтэрсэн. Хэтэрсэн шалтгаан нь MON-P4 болон MON-P5 зээлийн хүүгийн зардалд 1,103.8 сая төгрөг гарсантай холбоотой. Монгол Улсын Засгийн Газрын 132 дугаар тогтоолтой холбоотойгоор тус зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй.
3. Хөрс хуулалтын хойшлуулалтын зардал 3,085.4 сая төгрөгийг хойшлуулаагүй.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 3 зөрчилд албан шаардлага өгч, 2 зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт хийх, шууд худалдан авалтаар бараа бүтээгдэхүүн худалдан авсан, зорилтот түвшний биелэлтийг хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шивээ-Овоо ТӨХК-д дараах анхаарал татахуйц чухал асуудлууд байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээ /MON-P4, MON-P5/-гээр авсан урт хугацаат зээл, хүүгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулсан.
- ✓ Худалдан авалт

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөшгин шалгах шаардлагатай дараах дансдууд байна. Үүнд:

- ✓ Зардал, өртгийн тооцоололт
- ✓ Техник тоног төхөөрөмжийн сэлбэгийн орлого, түүний зарцуулалт зэргийг дахин нягталж үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 25, ашиг сонирхлын зөрчилгүй мэдээлэл 3, бусад төрлийн 32 мэдээлэл нийт 60 мэдээллийг оруулсан бөгөөд хугацаандаа 30, хугацаа хоцроосон мэдээлэл 30 байна.

Байгууллагын цахим хуудсанд компанийн мэдээлэл, холбогдох журам, заавар, нийгмийн хариуцлагын талаар хийсэн ажил, үйл ажиллагааны цаг үеийн мэдээ, мэдээллийг оруулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,125.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа гэсэн тайлбар өгсөн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шивээ-Овоо ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2019 оны жилийн эцсийн байдлаар 118.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

3.1.2 Эрсдэл: Авлага, өр төлбөрийн тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх, авлагыг барагдуулаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Авлагыг богино хугацаанд хураан барагдуулах, хугацаа хэтэрсэн авлага үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.

3.1.4 Үйлчлүүлэгчийн хариу: Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.2 Тэтгэмжийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тус компани нь хамтын гэрээний 6.2.1-д “өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд салбарт ажилласан жил тутамд салбарын хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. Үргэлжлүүлэн ажиллаж байгаа ахмадуудын тэтгэмжийг тэтгэвэр тогтоолгох үеийн ажилласан жилийг тооцож ажлаас халагдахад нь олгоно” гэж тусгасан байна. Энэ нь НББОУС 19-ийг зөрчиж байна.

3.2.2 Эрсдэл Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нягтлан бодох бүртгэл ба тодруулгыг тодорхойлох бөгөөд богино хугацааны тэтгэмж, Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, бусад урт хугацааны тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмжийг үнэн зөв тооцоогүй байх эрсдэлтэй.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт”-ыг мөрдөж ажиллах заалтын дагуу НББОУС 19-ийн дагуу тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө, шимтгэлийн тооцооллыг актуар төсөөллөөр тооцоолуулж байхаар заасан тул энэ стандартын дагуу мэргэжлийн актуарчин оролцуулан тооцож байх.

3.2.4 Үйлчлүүлэгчийн хариу: Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,357,313,468.20	1,210,847,131.18
Дансны авлага	7,368,110,746.24	7,434,785,719.61
Бусад авлага	663,639,723.61	127,869,675.37
Найдваргүй авлагын хасагдуулга	(3,191,012,968.00)	(3,191,012,968.00)
Бараа материал	14,639,936,260.40	14,871,214,262.92
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,058,490,155.79	2,917,980,920.69
Эргэлтийн хөрөнгийн дүн	24,896,477,386.24	23,371,684,741.77
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	66,807,487,688.67	68,768,470,897.73
Биет бус хөрөнгө	27,500,000.00	68,385,764.00
Хойшлогдсон татварын хөрөнгө	(2,674,133,497.20)	(2,674,133,497.20)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	530,131,395.40	530,131,395.40
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,066,825,493.78	786,228,029.78
Хөрс хуулалтын хөрөнгө	34,287,341,156.41	34,287,341,156.41
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,045,152,237.06	101,766,423,746.12
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	124,941,629,623.30	125,138,108,487.89
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	30,719,664,377.78	31,415,245,212.56
Цалингийн өглөг	729,129,375.66	847,157,177.00
Татварын өр	4,224,930,865.34	6,990,027,667.36
НДШ-ийн өглөг	877,244,396.29	3,263,452,148.55
Богино хугацаат зээл	1,499,999,999.98	2,300,000,000.00
Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10
Урьдчилж орсон орлого	36,772,504.49	52,523,979.42
Бусад богино хугацаат өр төлбөр	5,722,819,354.36	6,600,651,479.86
Богино хугацаат өр төлбөрийн дүн	43,823,602,784.00	51,482,099,574.85
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	2,354,027,050.71	2,596,846,461.03
Засгийн газрын дэмжлэг	59,195,878,218.04	59,195,878,218.04
Хойшлогдсон татварын өр	358,564,643.00	358,564,643.00
Бусад урт хугацаат өр төлбөр	13,049,041,059.36	12,861,489,355.18
Ажилчдын тэтгэврийн сан	1,343,643,750.00	1,218,522,661.73
Урт хугацаат өр төлбөрийн дүн	76,301,154,721.11	76,231,301,338.98
Өр төлбөрийн нийт дүн	120,124,757,505.11	127,713,400,913.83
Эздийн өмч		
Өмч: - төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
- хувийн	134,190,000.00	134,190,000.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,474,972,118.19	(3,917,192,425.94)
Эздийн өмчийн дүн	4,816,872,118.19	(2,575,292,425.94)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	124,941,629,623.30	125,138,108,487.89

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	50,777,682,082.66	55,700,795,807.46
Борлуулалтын өртөг	47,891,507,435.49	56,678,927,343.91
Нийт ашиг (алдагдал)	2,886,174,647.17	(978,131,536.45)
Түрээсийн орлого		0.00
Хүүний орлого	32,870,099.38	20,876,621.15
Ногдол ашгийн орлого		0.00
Эрхийн шимтгэлийн орлого		0.00
Бусад орлого	72,272,959.77	133,578,715.15
Борлуулалт маркетингийн зардал	1,109,252,077.52	1,124,776,522.40
Ерөнхий ба удирдлагын зардал	2,302,127,147.62	2,288,327,869.97
Санхүүгийн зардал	436,309,520.50	817,825,849.27
Бусад зардал	2,179,008,359.32	2,093,281,035.89
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(37,121,591.38)	(146,796,617.69)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	444,061,653.11	(167,658,181.66)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		0.00
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		0.00
Бусад ашиг (алдагдал)		0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,628,439,336.91)	(7,462,342,277.03)
Орлогын татварын зардал	3,231,941.36	2,087,663.30
Татварын дараах ашиг (алдагдал)	(2,631,671,278.27)	(7,464,429,940.33)
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,631,671,278.27)	(7,464,429,940.33)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	(2,631,671,278.27)	(7,464,429,940.33)

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	57,996,852,755.68	59,552,803,141.62
Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого	53,608,854,587.22	57,565,402,902.56
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого		0.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		0.00
Бусад мөнгөн орлого	4,387,998,168.46	1,987,400,239.06
Мөнгөн зарлагын дүн (-)	45,107,633,315.66	47,675,734,571.16
Ажилчдад төлсөн	6,337,201,400.79	8,256,819,635.23
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,929,455,879.00	661,864,850.00
Бараа материал худалдан авахад төлсөн	16,386,156,094.74	16,746,977,563.88
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,712,367,066.27	14,484,821,952.20
Хүүгийн төлбөрт төлсөн	411,479,152.66	499,506,945.13
Татварын байгууллагад төлсөн	2,621,942,489.28	1,710,457,338.79
Даатгалын төлбөрт төлсөн	69,338,632.00	
Бусад мөнгөн зарлага	5,639,692,600.92	5,315,286,285.93
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,889,219,440.02	11,877,068,570.46
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		0.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		0.00
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		0.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		0.00
Хүлээн авсан хүүгийн орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	9,578,298,768.97	11,400,127,673.80
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,589,073,130.00	7,148,186,418.09
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		0.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		0.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	5,989,225,638.97	4,251,941,255.71
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(9,578,298,768.97)	(11,400,127,673.80)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	5,000,000,000.00	8,200,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,000,000,000.00	8,200,000,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	7,768,735,106.89	8,823,407,233.68
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		7,730,396,175.98
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		899,018,191.50
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	3,607,520,000.02	0.00
Төлсөн ногдол ашиг	3,970,054,841.28	0.00
Буцалтгүй тусламж	191,160,265.59	193,992,866.20
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(2,768,735,106.89)	(623,407,233.68)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	542,185,564.16	(146,466,337.02)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	815,127,904.04	1,357,313,468.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,357,313,468.20	1,210,847,131.18

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)			
Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	5,261,814,991.89	1,341,900,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		844,828,404.57	844,828,404.57
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	6,106,643,396.46	7,448,543,396.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого			0.00
Өмчид гарсан өөрчлөлт			0.00
Зарласан ногдол ашиг			0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(2,631,671,278.27)	(2,631,671,278.27)
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	3,474,972,118.19	4,816,872,118.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		72,265,396.20	72,265,396.20
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	3,547,237,514.39	4,889,137,514.39
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(7,464,429,940.33)	(7,464,429,940.33)
Бусад дэлгэрэнгүй орлого			0.00
Өмчид гарсан өөрчлөлт			0.00
Зарласан ногдол ашиг		0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(3,917,192,425.94)	(2,575,292,425.94)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.05			САГ-2020/107/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Шивээ-овоо” ТӨХК		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогод стандартын өөрчлөлтийг тусгаагүй		Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
2	Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлагыг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, тооцоо нийлж баталгаажуулаагүй	118.3	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
3	Шивээ-Овоо ТӨХК нь 2019 онд сонгон шалгаруулалт хийлгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.		Албан шаардлага өгөх	Шивээ-овоо ТӨХК-ийн захирал	Ц.Энхтүвшин
4	Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.		Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
5	НББОУС 19-ийн дагуу тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө, шимтгэлийн тооцооллыг актуар төсөөллөөр тооцоолуулж байхаар заасан тул энэ стандартын дагуу мэргэжлийн актуарчин оролцуулан тооцож байх.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
	Дүн	118.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/147

Улаанбаатар хот

С.ӨТ- 2020/107/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-овоо ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт хийх, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй шууд худалдан авалтаар бараа бүтээгдэхүүн худалдан авсан зорилтот түвшний биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шивээ-овоо ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Энхжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЗУЛ

"ПАНТЕР МИДЛАНД АУДИТ" ХХК
АУДИТОР Ц.АЯТАНЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

ШИВЭЭ-ОВОО ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ц.ЭНХТҮВШИН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Н.ЭНХЖАРГАЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

